



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/70

Мандалговь

Сум дундын ойн ангийн албан хэрэгцээнд  
бага оврын автомашин хүлээлцэх  
комисс томилох тухай

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1, 4.13 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Сум дундын ойн ангийн албан хэрэгцээнд бага оврын автомашин хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ц.Галбадрах (Сум дундын ойн ангийн дарга)

Гишүүд: Ц.Даваа (Орон нутгийн өмчийн газрын бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

А.Нэргүй (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч)

У.Батхишиг (Хишиг нано констракшн ХХК)

Хоёр. Сум дундын ойн ангийн албан хэрэгцээнд бага оврын автомашиныг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

486190163